

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 11 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

Г “Туул сонгино усны нөөц” ХК-ийн талаар авч
г хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалт болон “Туул сонгино усны нөөц” ХК-ийн үйл ажиллагаанд шалгал хийсэн ажлын хэсгийн тайлан дүгнэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 2007 оны 33 дугаар тогтоолоор үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн “Туул сонгино усны нөөц” ХК-ийн 120 000 000 ширхэг зарласан хувьцаанаас гаргаагүй үлдсэн 91 410 000 ширхэг хувьцаа болон үүсгэн байгуулагч болох Г.Ганбатын 13 448 044 ширхэг хувьцаа, нийт 104 858 044 ширхэг хувьцааг бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/ -д тус тус үүрэг болгосугай.

2. Төслийн хэрэгжилт удааширсантай холбогдуулж жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор 199 хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдох 390 783 000 төгрөгийн хөрөнгийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь “Туул сонгино усны нөөц” ХК-ийн дансанд 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор байршуулахыг “Туул сонгино усны нөөц” ХК /Марат Утегенов/-д даалгасугай.

3. Төслийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хувь нийлүүлэгчдийн хурлаараа ойрын хугацаанд хэлэлцүүлж дүнг тус Хороонд мэдэгдэхийг “Туул сонгино усны нөөц” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Алишер Джуманов/, Гүйцэтгэх захирал /Марат Утегенов/-д тус тус даалгасугай.

4. Үүсгэн байгуулагчдын компанид оруулсан бодит хөрөнгө, тэдгээрийн үнэлгээ, уг хөрөнгөд ногдох хувьцаа болон компани төсөл хэрэгжүүлэх зорилгоор зарцуулсан хөрөнгө, компанийн өмчлөлд авсан хөрөнгө болон авлагын асуудлаар компанийн хүрээнд нэг мөр шийдвэр гаргаж зохих журмаар гүйцэтгэлээ хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулан чиглэл авч гүйцэтгэлийн тайлангаа 2010 оны эхний улиралд багтаан Хороонд ирүүлэхийг “Туул сонгино усны нөөц” ХК /Марат Утегенов/-д даалгасугай.

5. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хувь нийлүүлэгчдийн хурлаараа батлах хүртэлх хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийг гадаад болон дотоодын үнэт цаасны захад байршуулахгүй байх, нийт хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах, шаардлагагүй зардал гаргахгүй байх, гадаад болон дотоодын хөрөнгийн зах зээлд оруулсан гэх хөрөнгө оруулалтыг эргүүлэн татаж хадгаламж хэлбэрээр болон түүнтэй адилтгах хэлбэрээр банкинд 2009 оны 12 дугаар сард багтаан байршуулж тус Хороонд эргэн тайлагнахыг “Туул сонгино усны нөөц” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /А.Джуманов/ Гүйцэтгэх захирал /М.Утегенов/-д тус тус даалгасугай.

6. Энэхүү тогтоолын 2-оос 5 дахь заалтад заасан арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж холбогдох шийдвэр гаргах хүртэл хугацаанд энэхүү тогтоолын хавсралтад дурьдсан хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тусгаарласугай.

7. Энэхүү тогтоолын 2-т заасан хөрөнгөнөөс гагцхүү Хорооноос өгсөн зөвшөөрлийн дагуу гүйлгээ хийж ажиллахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/ -д үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоолын 6-д заасан Хорооны шийдвэр гарах хүртэлх хугацаанд энэ тогтоолоор өгөгдсөн үүргүүдийн хэрэгжилтийн явцыг сар бүрийн эхний долоо хоногт багтаан Хороонд бичгээр тайлагнаж байхыг “Туул сонгино усны нөөц” ХК /МаратУтегенов/-дүүрэг болгосугай.

9. “Туул сонгино усны нөөц” ХК-ийн үнэт цаас гаргах үйл ажиллагаанд болон төслийг боловсруулахад хэрхэн оролцсон болон андеррайтерийн хувьд ямар үнэ өртгөөр ямар үйлчилгээ үзүүлсэн, ямар хариуцлага хүлээхээр гэрээ байгуулсан тухай дүгнэлт тайлбараа холбогдох баримтын хамт 2009 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Бидисек” ХК /Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

10. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгий зохицуулах хорооны 2009 оны 252
дугаар тогтоолын хавсралт

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэгээр
1	Firebird global Master fund2	69 732,00
2	“Евразиа капитал монголиа” ХХК	500 003,00
3	Капитрон банк	1 000 000,00
4	Eastinvestor fund	1 000 000,00
5	Opportunity fund	1 600 000,00
6	Discovery fund	2 030 832,00
7	Firebird global Master fund1	3 424 898,00
8	Mongolia capital fund	3 733 752,00
9	Г.Ганбат	1 001 956,00
10	Г.Ганцэцэг	390 000,00